

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 51-261628 Цахим хаяг: enkbaatare@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: О.Наранбат Утас: 51-261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/824

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Гаалийн ерөнхий газар нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсын жишигт нийцсэн ухаалаг, цахим гаалийн хяналтыг зохион байгуулж, импортын барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэх “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-ийг нээж, харьяа газар, хороодод үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн байна.

### Аудитын гол асуудал

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 5,720.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,328.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 93.2 хувьтай байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Гаалийн ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 92.6 хувиар үнэлж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт энэ мэдээллийг хамруулаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,696,511.4</b>	<b>46,431,848.1</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,953,891.1	19,427,443.8
33	АВЛАГА	148,443.6	617,197.3
34	УРЬДЧИЛГАА	5,449.8	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,313,620.2	11,400,371.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	18,275,106.7	14,986,835.1
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>163,369,909.3</b>	<b>167,868,665.1</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	163,369,909.3	167,868,665.1
39200	Биет хөрөнгө	153,178,770.9	158,966,721.5
39300	Биет бус хөрөнгө	10,191,138.4	8,901,943.6
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>192,066,420.7</b>	<b>214,300,513.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,990,099.4</b>	<b>18,911,996.9</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,990,099.4	18,911,996.9
41300	Өглөг	1,990,099.4	18,911,996.9
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>190,076,321.3</b>	<b>195,388,516.3</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>190,076,321.3</b>	<b>195,388,516.3</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	72,491,824.4	72,646,284.8
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>110,802,814.9</b>	<b>115,960,549.4</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,781,682.1	6,781,682.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>192,066,420.7</b>	<b>214,300,513.2</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>108,590,346.2</b>	<b>131,267,936.2</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,035,715.2</b>	<b>14,979,181.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого	32,035,715.2	14,979,181.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,554,631.0	116,288,755.3
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>82,327,014.0</b>	<b>103,083,921.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,327,014.0	103,083,921.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,329,378.2	87,483,246.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,207,231.0	47,426,372.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,496,095.8	5,982,067.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,844,940.1	4,070,707.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,151,132.2	1,439,345.1
2105	Нормативт зардал	2,750,499.2	1,983,885.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,625,532.4	1,294,212.0
2107	Томилолт, зочны зардал	234,455.3	450,140.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,961.4	2,905,834.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,859,530.8	21,930,681.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,997,635.8</b>	<b>15,600,674.5</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>26,263,332.1</b>	<b>28,184,014.8</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,118,856.0</b>	<b>22,961,339.7</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>25,144,476.2</b>	<b>5,222,675.2</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	ЗГ-ын оруулсан капитал	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>71,160,406.4</b>	<b>163,676,581.2</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	121,834.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,160,406.4	163,798,415.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(136,814.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	(61,173.9)
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,331,418.0	1,331,418.0
9	Тайлант үеийн үр дүн	0.00	25,144,476.2
<b>10</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,491,824.4</b>	<b>190,076,321.3</b>
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	154,460.4	89,519.8
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>72,646,284.8</b>	<b>190,165,841.1</b>
19	Тайлант үеийн үр дүн	0.00	5,222,675.2
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,646,284.8</b>	<b>195,388,516.3</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>90,108,930.4</b>	<b>139,600,158.7</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,524,500.7</b>	<b>23,227,496.7</b>
120	Нийтлэг татварын бус орлого	13,524,500.7	23,227,496.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,584,429.7	116,372,661.9
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>68,095,107.9</b>	<b>86,220,468.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>68,095,107.9</b>	<b>86,220,468.7</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,931,742.0	69,889,656.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,051,132.2	47,304,618.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,507,450.2	6,052,024.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,926,332.0	4,096,779.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,117,766.2	1,156,541.6
2105	Нормативт зардал	4,745,857.4	2,086,684.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,888,263.9	2,799,131.7
2107	Томилолт, зочны зардал	234,496.6	450,611.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,202,511.2	4,002,544.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,257,932.3	1,940,719.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,163,365.9	16,330,812.4
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>22,013,822.5</b>	<b>53,379,690.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>21,972,427.1</b>	<b>35,906,137.3</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,972,427.1</b>	<b>35,906,137.3</b>
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,972,427.1)	(35,906,137.3)
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>41,395.4</b>	<b>17,473,552.7</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,912,495.7	1,953,891.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,953,891.1	19,427,443.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>114,080,464,800.00</b>	<b>106,370,857,659.23</b>	<b>7,709,607,140.77</b>	<b>93.2</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>85,002,479,000.00</b>	<b>73,931,957,746.07</b>	<b>11,070,521,253.93</b>	<b>86.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>80,212,707,900.00</b>	<b>70,165,517,301.74</b>	<b>10,047,190,598.26</b>	<b>87.5</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>55,169,291,800.00</b>	<b>47,304,618,726.11</b>	<b>7,864,673,073.89</b>	<b>85.7</b>
Үндсэн цалин	26,193,962,300.00	23,354,236,165.35	2,839,726,134.65	89.2
Нэмэгдэл	18,708,165,900.00	15,530,549,219.25	3,177,616,680.75	83.0
Унаа хоолны хөнгөлөлт	3,896,795,300.00	3,181,455,965.22	715,339,334.78	81.6
Урамшуулал	6,370,368,300.00	5,238,377,376.29	1,131,990,923.71	82.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,731,339,200.00</b>	<b>6,052,024,911.65</b>	<b>679,314,288.35</b>	<b>89.9</b>
Тэтгэврийн даатгал	4,836,830,100.00	4,406,450,685.39	430,379,414.61	91.1
Тэтгэмжийн даатгал	484,053,500.00	401,420,612.75	82,632,887.25	82.9
ҮОМШӨ-ний даатгал	385,920,600.00	317,483,356.89	68,437,243.11	82.3
Ажилгүйдлийн даатгал	96,190,600.00	78,794,616.25	17,395,983.75	81.9
Эрүүл мэндийн даатгал	928,344,400.00	847,875,640.37	80,468,759.63	91.3
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,461,860,000.00</b>	<b>4,096,779,252.04</b>	<b>365,080,747.96</b>	<b>91.8</b>
Гэрэл, цахилгаан	1,854,050,000.00	1,726,682,427.30	127,367,572.70	93.1
Түлш, халаалт	2,209,400,000.00	1,994,229,636.49	215,170,363.51	90.3
Цэвэр, бохир ус	323,100,000.00	301,757,188.25	21,342,811.75	93.4
Байрны түрээс	75,310,000.00	74,110,000.00	1,200,000.00	98.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,327,603,500.00</b>	<b>1,168,441,628.21</b>	<b>159,161,871.79</b>	<b>88.0</b>
Бичиг хэрэг	188,263,200.00	176,190,145.00	12,073,055.00	93.6
Тээвэр, шатахуун	587,200,000.00	532,001,063.00	55,198,937.00	90.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,488,600.00	62,037,733.26	16,450,866.74	79.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,504,000.00	29,193,723.95	10,310,276.05	73.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	434,147,700.00	369,018,963.00	65,128,737.00	85.0
<b>Нормативт зардал</b>	<b>2,146,651,900.00</b>	<b>2,086,684,521.00</b>	<b>59,967,379.00</b>	<b>97.2</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490,587,600.00	467,041,260.00	23,546,340.00	95.2
Хоол, хүнс	146,864,300.00	136,079,261.00	10,785,039.00	92.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,509,200,000.00	1,483,564,000.00	25,636,000.00	98.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,019,023,200.00</b>	<b>3,760,303,900.95</b>	<b>258,719,299.05</b>	<b>93.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	2,279,240,000.00	2,211,125,477.00	68,114,523.00	97.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	146,031,200.00	112,922,047.00	33,109,153.00	77.3
Урсгал засвар	1,593,752,000.00	1,436,256,376.95	157,495,623.05	90.1
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>550,447,300.00</b>	<b>450,611,637.00</b>	<b>99,835,663.00</b>	<b>81.9</b>

Гадаад албан томилолт	180,000,000.00	176,501,210.00	3,498,790.00	98.0
Дотоод албан томилолт	370,447,300.00	274,110,427.00	96,336,873.00	73.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,422,086,000.00</b>	<b>4,010,503,581.14</b>	<b>411,582,418.86</b>	<b>90.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,278,665,600.00	2,953,706,952.95	324,958,647.05	90.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,847,200.00	11,217,600.00	5,629,600.00	66.6
Даатгалын үйлчилгээ	82,436,400.00	74,998,233.41	7,438,166.59	91.0
Тээврийн хэрэгслийн татвар	12,201,600.00	8,767,055.00	3,434,545.00	71.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,681,600.00	2,165,893.00	1,515,707.00	58.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	205,150,300.00	169,108,263.78	36,042,036.22	82.4
Газрын төлбөр	24,533,000.00	21,576,453.00	2,956,547.00	88.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	798,570,300.00	768,963,130.00	29,607,170.00	96.3
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,384,405,000.00</b>	<b>1,235,549,143.64</b>	<b>148,855,856.36</b>	<b>89.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,165,714,800.00	1,029,013,007.64	136,701,792.36	88.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	218,690,200.00	206,536,136.00	12,154,064.00	94.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,789,771,100.00</b>	<b>3,766,440,444.33</b>	<b>1,023,330,655.67</b>	<b>78.6</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>105,000,000.00</b>	<b>98,310,651.33</b>	<b>6,689,348.67</b>	<b>93.6</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	105,000,000.00	98,310,651.33	6,689,348.67	93.6
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,684,771,100.00</b>	<b>3,668,129,793.00</b>	<b>1,016,641,307.00</b>	<b>78.3</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	466,000,000.00	466,000,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,331,084,200.00	741,137,236.00	589,946,964.00	55.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,887,686,900.00	2,460,992,557.00	426,694,343.00	85.2
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,077,985,800.00</b>	<b>32,438,899,913.16</b>	<b>(3,360,914,113.16)</b>	<b>111.6</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>29,077,985,800.00</b>	<b>32,438,899,913.16</b>	<b>(3,360,914,113.16)</b>	<b>111.6</b>
Барилга байгууламж	1,198,400,000.00	5,146,076,889.44	(3,947,676,889.44)	429.4
Тоног төхөөрөмж	27,879,585,800.00	27,292,823,023.72	586,762,776.28	97.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>100,715,691,000.00</b>	<b>106,368,305,459.23</b>	<b>(5,652,614,459.23)</b>	<b>105.6</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>99,488,543,800.00</b>	<b>104,290,965,778.97</b>	<b>(4,802,421,978.97)</b>	<b>104.8</b>
Улсын төсвөөс санхүүжих	99,488,543,800.00	104,290,965,778.97	(4,802,421,978.97)	104.8
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,227,147,200.00</b>	<b>2,077,339,680.26</b>	<b>(850,192,480.26)</b>	<b>169.3</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,227,147,200.00	2,077,339,680.26	(850,192,480.26)	169.3

<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>6,315,600.70</b>	<b>(6,315,600.70)</b>	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>3,763,400.70</b>	<b>(3,763,400.70)</b>	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>4653</b>	<b>3823</b>	<b>830</b>	<b>82.2</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>2326</b>	<b>1911</b>	<b>415</b>	<b>82.2</b>
Удирдах ажилтан	90	90	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1869	1454	415	82.2
Үйлчлэх ажилтан	367	367	0	100
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>2326</b>	<b>1911</b>	<b>415</b>	<b>82.2</b>
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1904	1463	441	76.8
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	422	448	(26)	106.2
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	176	0	176	0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>873,337,817.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>787,829,817.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>85,095,500.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>2,000,000.00</b>
210401	Бичиг хэрэг		2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>18,900,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		18,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>34,195,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		34,195,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>30,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		30,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>702,734,317.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>57,678,620.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		57,678,620.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>645,055,697.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		72,126,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		572,929,697.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>85,508,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>85,508,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		85,508,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>873,337,817.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>873,337,817.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		236,858,120.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		606,479,697.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Гаалийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 20 байгууллагын тайланг нэгтгэснээс 14 байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт гаргаж, 6 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

#### **Төвлөрүүлэн захирагч**

ГЕГ нь тайлант онд худалдан авсан 16.5 сая төгрөгийн алба хаагчдын видео сургалтын материалыг бараа материалын дансанд бүртгэлгүй шууд зардлаар бүртгэснийг залруулав.

Аудитаар нийт 381.0 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

#### **Албан шаардлага**

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,248.8 сая төгрөгийн 43 алдаа, 176.5 сая төгрөгийн 28 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 277.9 сая төгрөгийн 11 зөрчил илэрсэн нь өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** ГЕГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт өмнөх аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Төсвийн үр ашигтай зарцуулалттай холбоотой

**Илрүүлэлт:** Тайлант онд СХОГ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилэн дансны хөндлөнгийн мониторинг хийх үйлчилгээний төлбөрт 5.5 сая төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйл 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шилэн дансны хөндлөнгийн мониторинг хийлгэхгүй байх

##### 2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Илрүүлэлт: СХОГ нь 375.5 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэхдээ өглөгийн дансаар дамжуулан давхар бичилт хийлгүй шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлж байх

Аудитаар нийт 1,408.4 сая төгрөгийн 44 алдаа<sup>2</sup> илэрснээс аудитын явцад 1,275.8 сая төгрөгийн 42 алдааг залруулж, залруулаагүй 2 алдаа, 132.6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гашуун сухайт дахь ГГ	4	63,958.6	-	-	4	63,958.6	4	63,958.6				
Орхон аймаг дахь ГГ	4	6,613.2	1	5,013.1	3	1,600.1	4	6,613.2				
Сэлэнгэ аймаг дахь ГГ	1	1,329.0	-	-	1	1,329.0	1	1,329.0				
Увс аймаг дахь ГГ	1	14,000.0	1	14,000.0	-	-	1	14,000.0				
Ховд аймаг дахь ГГ	1	1,839.0	-	-	1	1,839.0	1	1,839.0				
Чингис хаан олон улсын нисэх буудал дахь ГГ	3	8,480.0	1	6,500.0	2	1,980.0	2	8,480.0	1	-	1	-
Говь-Алтай аймаг дахь ГХ	1	2,405.1	1	2,405.1	-	-	1	2,405.1				
Шивээ хүрэн дэх ГГ	5	731,978.5	-	-	5	732,978.5	5	731,978.5				
УХШИГГ	11	400,030.2	2	200,081.2	9	199,949.0	10	267,430.2	1	132,600.0	1	132,600.0
Улаанбаатар хот дахь ГГ	12	161,303.8	2	55,027.1	10	106,276.7	12	161,303.8				
<b>Харьяа байгууллагын дүн</b>	<b>43</b>	<b>1,391,937.4</b>	<b>8</b>	<b>283,026.5</b>	<b>35</b>	<b>1,108,910.9</b>	<b>41</b>	<b>1,259,337.4</b>	<b>2</b>	<b>132,600.0</b>	<b>2</b>	<b>132,600.0</b>
<b>Түүврийн байгууллага</b>												
ГЕГ-СХОХ	1	16,500.0			1	16,500.0	1	16,500.0				

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<b>Нийт</b>	<b>44</b>	<b>1,408,437.4</b>	<b>8</b>	<b>283,026.5</b>	<b>36</b>	<b>1,125,410.9</b>	<b>42</b>	<b>1,275,837.4</b>	<b>2</b>	<b>132,600.0</b>	<b>2</b>	<b>132,600.0</b>
-------------	-----------	--------------------	----------	------------------	-----------	--------------------	-----------	--------------------	----------	------------------	----------	------------------

Аудитаар нийт 557.5 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс, 3.4 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 116.6 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 437.5 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гашуун сухайт дахь ГГ	3	16,642.0					3	16,642.0				
Говь-Алтай аймаг дахь ГХ	3	3,342.0			2	3,342.0	1	-				
Дархан-Уул аймаг дахь ГГ	1	227.0	1	227.0								
Дорнод аймаг дахь ГГ	1	10,818.5					1	10,818.5				
Орхон аймаг дахь ГГ	3	16,081.7	1	1,593.8			2	14,487.9				
Сэлэнгэ аймаг дахь ГГ	1	-					1	-				
Увс аймаг дахь ГГ	2	8,040.0			1	8,040.0	1	-				
Чингис хаан олон улсын нисэх буудал дахь ГГ	1	71,937.0			1	71,937.0						
Шивээ хүрэн дэх ГГ	3	8,228.0					3	8,288.0				

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

УХШИГГ	5	11,226.2			2	4,967.8	3	6,258.4				
Улаанбаатар хот дахь ГГ	4	21,471.1	3	1,547.5	1	19,923.6						
Сайншанд дахь ГГ	1	8,388.3			1	8,388.3						
<b>Харьяа байгууллагын дүн</b>	<b>28</b>	<b>176,461.8</b>	<b>5</b>	<b>3,368.3</b>	<b>8</b>	<b>116,598.7</b>	<b>15</b>	<b>56,494.8</b>				
<b>Түүврийн байгууллага</b>												
СХОХ	3	381,005.5			1	-	2	381,005.5				
<b>Нийт</b>	<b>31</b>	<b>557,467.3</b>	<b>5</b>	<b>3,368.3</b>	<b>9</b>	<b>116,598.7</b>	<b>17</b>	<b>437,500.3</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 311.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 124.6 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 186.9 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Гашуун сухайт дахь ГГ	2	11,545.5			-	-	2	11,545.5
Дархан-Уул аймаг дахь ГГ	1	5,625.0			-	-	1	5,625.0
Сэлэнгэ аймаг дахь ГГ	1	-			-	-	1	-
Шивээ хүрэн дэх ГГ	1	77,738.0			-	-	1	77,738.0
УХШИГГ	1	3,300.0			1	3,300.0	-	-
Улаанбаатар хот дахь ГГ	1	37,287.5			-	-	1	37,287.5
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>135,496.0</b>			<b>1</b>	<b>3,300.0</b>	<b>6</b>	<b>132,196.0</b>

<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Увс аймаг дахь ГГ	2	116,380.6			1	95,200.0	1	21,180.6
УХШИГГ	1	-			-	-	1	-
Улаанбаатар хот дахь ГГ	1	26,063.7			1	26,063.7	-	-
<b>Харьяа байгууллагын дүн</b>	<b>11</b>	<b>277,940.3</b>			<b>3</b>	<b>124,563.7</b>	<b>8</b>	<b>153,376.6</b>
<b>Түүврийн байгууллага</b>								
ГЕГ-ын ААҮА	1	33,518.8					1	33,518.8
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>311,459.1</b>			<b>3</b>	<b>124,563.7</b>	<b>9</b>	<b>186,895.4</b>